

Агуулга

Тайланг бэлтгэсэн:

Говь-Алтай аймаг дахь Төрийн
аудитын газрын

II баг

Дарга, Тэргүүлэх аудитор

Х.Түвшинбаяр

Аудитын менежер

Д.Эрдэнэчимэг

Ахлах аудитор

Б.Цэцэгмаа

Аудитор

Х.Билэгбаяр

Э.Сүнжидмаа

2017 оны 09 дүгээр сар

Аудитын тайлантай холбоотой
асуудлаар нэмж тодруулах,
асууж лавлах зүйл байвал
99488754, 99844944, 94009818
дугаарын утас, ажлын 70484030,
70483413 дугаарын факсаар
харилцана уу.

Хаяг:

Говь-Алтай аймаг

Есөнбулаг сум

Товчилсон үгийн жагсаалт

Аудитын зорилт, хамрах хүрээ, арга зүй

Бүлэг 1

Иргэд, аж ахуйн нэгжүүд татварын хөнгөлөлт
чөлөөлөлт эдлэх боломжоо хангалттай түвшинд
ашиглахгүй байна.

Бүлэг 2

Татварын хөнгөлөлт, чөлөөлөлтөд хамрагдсан аж
ахуйн нэгжүүдийн тухайд зохих хяналтыг
хэрэгжүүлэн ажиллажээ.

Ерөнхий дүгнэлт:

**ШИНЭЧЛЭГДСЭН ХУУЛИУДЫГ ТАНИУЛАН
СУРТАЛЧЛАХ АЖИЛ ХАНГАЛТГҮЙГЭЭС
ТАТВАРЫН ХӨНГӨЛӨЛТ, ЧӨЛӨӨЛӨЛТ ЭДЭЛЖ
БУЙ АЖ АХУЙН НЭГЖИЙН ТОО ЦӨӨН БАЙНА.**

Зөвлөмж

Албан шаардлага

Акт

Холбогдох байгууллагын санал

Хавсралтууд

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

ААНОАТ	Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар
ААНБ	Аж ахуйн нэгж байгууллага
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
ББН	Бүх гишүүд нь бүрэн хариуцлагатай нөхөрлөл
ББӨ	Борлуулсан бүтээгдэхүүний өртөг
БО	Борлуулалтын орлого
ГАГ	Гүйцэтгэлийн аудитын газар
ГА	Гүйцэтгэлийн аудит
ЗБН	Зарим гишүүд нь бүрэн хариуцлагатай нөхөрлөл
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
НӨАТ	Нэмэгдсэн өртгийн албан татвар
ОУБ	Олон Улсын байгууллага
ҮАГ	Үндэсний аудитын газар
ТЕГ	Татварын ерөнхий газар
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани

АУДИТЫН НЭР: “Татварын хөнгөлөлт чөлөөлөлтийн бодлого, түүний хэрэгжилт үр дүн”

АУДИТЫН КОД: УАГ-ГАГ-/2017/10-ГА

АУДИТ ХИЙХ ҮНДЭСЛЭЛ БҮРЭН ЭРХ

Аудитыг Улсын их хурлын Төсвийн байнгын хорооны 2017 оны 02 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2017 оны А/12 дугаар тушаал болон Үндэсний аудитын газрын аудитын ажлын төлөвлөгөө, Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газрын үйл ажиллагааны төлөвлөгөөг үндэслэн Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон бүрэн эрхийн хүрээнд хийж гүйцэтгэлээ.

АУДИТЫН ЗОРИЛТ

Татварын хөнгөлөлт чөлөөлөлтийн бодлого, хэрэгжилт, үр дүнг шалгаж дүгнэлт гарган зөвлөмж боловсруулан, холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилт чиглэгдэв. Аудитын зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг хийлээ.

- ✓ Татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийн талаарх бодлого, зохицуулалт үр дүнтэй хэрэгжиж байгаа эсэх
- ✓ Татварын хөнгөлөлт, чөлөөлөлтөд тавих хяналт үр нөлөөтэй хэрэгжиж байгаа эсэх

ХАМРАХ ХҮРЭЭ

Аудитыг 2015-2016 оны байдлаарх татварын хуулийн хөнгөлөлт, чөлөөлөлтийн талаар баримталсан бодлого, судалгаа, ухаалаг систем, цахим тайлан, аж ахуйн нэгжийн тайлан түүний анхан шатны баримт материал болон бусад баримт материалд үндэслэн Говь-Алтай аймгийн Татварын хэлтсийн тайлан мэдээ, судалгаанд тулгуурлан 2015-2016 онуудад хөнгөлөлт чөлөөлөлт эдэлсэн аж ахуйн нэгж байгууллагуудыг 10.0 сая төгрөгөөс дээш борлуулалтын орлоготой аж ахуйн нэгжүүдийг сонгон авч шалгалаа.

АРГА ЗҮЙ СТАНДАРТЫН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ

Аудитыг гүйцэтгэхэд Төрийн хяналт шалгалтын стандарт, гүйцэтгэлийн аудитын удирдамж (АДБОУС 3000-3100) арга зүйг ашиглан төрийн байгууллага, нэгжийн холбогдох албан тушаалтантай ярилцлага хийх, асуулга, лавлагаа, тодруулга авах, хамрах хүрээ, арга хэлбэр, хүрсэн үр дүнг үндсэн үзүүлэлт, шилдэг практик, арга туршлагатай харьцуулах, цуглуулсан судалгаа, шинжилгээний баримт материалд дүн шинжилгээ хийх зэрэг арга зүйг ашиглахын зэрэгцээ аудитын хөтөлбөр, горимын дагуу шаардлагатай нотлох зүйлсийг цуглуулж аудитын дүнд үндэслэн дүгнэлт, шийдвэрийг боловсруулан ажилалаа.

ЭРСДЛИЙН ҮНЭЛГЭЭ

Урьдчилсан судалгааны явцад хийсэн дүн шинжилгээ, харилцан ярилцлагад үндэслэн ерөнхий эрсдэлийг **"ДУНД"** гэж үнэлэв.

ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

Аудитад дараах хууль эрхийн актыг шалгуур үзүүлэлт болгоно.

- ✓ Татварын ерөнхий хууль
- ✓ Аж ахуй нэгжийн орлогын албан татварын тухай хууль
- ✓ Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хууль
- ✓ Нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх тухай
- ✓ Хувь хүний орлогын албан татварын тухай хууль
- ✓ Төсвийн тухай хууль
- ✓ Төрийн аудитын тухай хууль

- ✓ Дээрхи хуулийг хэрэгжүүлсэнтэй холбогдуулан гаргасан УИХ, Засгийн газрын тогтоол, бусад эрх зүйн актууд
- ✓ Холбогдох бусад хууль тогтоомж, эрхийн акт стандарт

АУДИТЫН ХУГАЦАА

Аудитын төлөвлөлтийн үе шатны ажлыг 2017 оны 07 дугаар сарын 19-нөөс 07 дугаар сарын 24-ний хооронд хэрэгжүүлж, Талбарын үе шатны ажлыг 08 сарын 16-наас эхлүүлж 08 дугаар сарын 25-ны өдөр дуусгаж удирдлагын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн Тэргүүлэх аудиторoor батлуулан 2017 оны 09 дүгээр сарын 04-ний өдрийн дотор ҮАГ-ын Гүйцэтгэлийн аудитын газарт хүргүүлээ.

АУДИТЫН БАГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Аудитыг Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Х.Түвшинбаяр удирдаж, аудитын менежер Д.Эрдэнэчимэг үе шатны болон чанарын хяналтыг хэрэгжүүлэн стандартыг хангуулж, ахлах аудитор Б.Цэцэгмаа, аудитор Э.Сүнжидмаа, Х.Билэгбаяр нар ҮАГ-аас батлагдан ирсэн төлөвлөгөө, хөтөлбөр болон аймагт боловсруулан тэргүүлэх аудиторoor батлуулсан дэд төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу хийж гүйцэтгэлээ.

АУДИТ ХИЙХЭД ГАРСАН ХҮНДРЭЛ БЭРХШЭЭЛ

Уг аудитын хийж гүйцэтгэхэд татварын хэлтсийн холбогдох байцаагч нар ээлжийн амралтаа авсан байснаас гадна Татварын хэлтэс нь: Аж ахуй нэгжийн орлогын албан татвар болон нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн дагуу хөнгөлөлт, чөлөөлөлт эдэлсэн байгууллагын анхан шатны баримтыг татварын ерөнхий хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4¹ заасны дагуу гаргаж өгөх боломжгүй гэсэн тул ААНБ тус бүртэй утсаар холбоо барьж баримт материалыг гаргуулан авахад өмнөх онуудын баримт материал байхгүй байх, зуны амралтын үе таарсан учир ААН-ийн эзэд амралт, сувилалд явсан зэрэг цаг хугацаа алдах шалтгаан боллоо.

¹ Энэ хуулийн 14.3-т зааснаас бусад тохиолдолд татвар төлөгчийн зөвхөн бичгээр өгсөн зөвшөөрлийг үндэслэн хуулиар хориглоогүй мэдээ, баримтуудыг танилцуулж болно.

14.3. Татварын алба, татварын улсын байцаагч, татварын албаны бусад ажилтан нь албан үүргээ гүйцэтгэх явцад олж мэдсэн Хувь хүний нууцын тухай хууль болон Байгууллагын нууцын тухай хуулиар тодорхойлсон татвар төлөгчийн нууцыг хадгалах үүрэгтэй бөгөөд зөвхөн төрийн байгууллагын дор дурдсан албан тушаалтанд татварын албаны даргын шийдвэрээр танилцуулж болно:

14.3.1. татварын хууль тогтоомжийн дагуу албан үүргээ гүйцэтгэж байгаа татварын улсын байцаагч, татварын албаны бусад ажилтан;

14.3.2. татварын хууль тогтоомжийн зөрчлийг шалгах, хянах, шийдвэрлэх үүрэг хүлээсэн мөрдөгч, прокурор, шүүгчид уг зөрчилд нь холбогдох асуудлаар;

ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Татварын ерөнхий хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.1², 9.1.2³ дэх заалтаар татвараас хөнгөлөх, 9.1.3⁴, 9.1.4⁵, 9.1.5⁶ дахь заалтаар татвараас чөлөөлөх төрөл, хэлбэрийг тогтоосон байна. Говь-Алтай аймгийн тухайд 2015-2016 онд нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 13 дугаар зүйлийн дагуу давхардсан тоогоор 27 аж ахуйн нэгж байгууллага, 1 иргэн хамрагдаж 858.9 сая төгрөгийн чөлөөлөлт эдэлсэн байна.

Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1.1⁷, 19.1.4⁸ дахь заалтын дагуу 2015 онд 5 аж ахуйн нэгжийн 0.19 сая төгрөгийн, 2016 онд 6 аж ахуйн нэгжийн 0.19 сая төгрөгийг албан татвараас хөнгөлсөн ба 1 аж ахуйн нэгжийн 109.1 сая төгрөгийн борлуулалтын орлогыг ААНОАТ-аас чөлөөлсөн байна.

Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1⁹ дахь заалт, 24 дүгээр зүйлийн 24.6¹⁰, 24.7¹¹ дахь заалтын дагуу 2015 онд 554 иргэнд 381.4 сая төгрөгийн орон сууц худалдан авсан орлогын татварын чөлөөлөлт, 697 иргэнд 135.7 сая төгрөгийн сургалтын төлбөр төлсөн орлогын хөнгөлөлт эдлүүлсэн байна. 2016 онд 540 иргэнд 357.1 сая төгрөгийн орон сууцны чөлөөлөлт, 794 иргэнд 163.6 сая төгрөгийн сургалтын төлбөрийн хөнгөлөлт эдлүүлсэн байна.

Онцгой албан татварын тухай хууль, Гаалийн тариф, гаалийн татварын тухай хууль, Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хуулиудын хүрээнд хөнгөлөлт чөлөөлөлтөнд хамрагдсан аж ахуйн нэгж байгууллага бүртгэгдээгүй байна.

Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн хүрээнд 2015-2016 онд 2585 иргэнд 1,037.8 сая төгрөгийн татварын хөнгөлөлт чөлөөлөлт эдлүүлсэн байна. ХХОАТ-ын тухай хуулийн хэрэгжилт буюу хөнгөлөлт, чөлөөлөлт эдэлсэн иргэдийн материалд хууль хэрэгжиж эхэлсэн оноос хойш 2015 онд олгосон хөнгөлөлт чөлөөлөлтийн баримтыг, 2015 онд хийсэн “Татвар болон татварын бус орлогын төлөвлөлт бүрдүүлэлт, үр дүн”

² 9.1.1. ногдуулсан татварыг хорогдуулах;

³ 9.1.2. татварын хувь, хэмжээг бууруулах;

⁴ 9.1.3. тогтоосон доод хэмжээнд хүрээгүй орлого, эд хөрөнгө, бараа, ажил, үйлчилгээг татвараас чөлөөлөх;

⁵ 9.1.4. татвар төлөгчийг татвараас чөлөөлөх;

⁶ 9.1.5. татвар ногдох зүйлийн зохих хэсгийг татвараас чөлөөлөх;

⁷ 19.1.1. үр тариа, төмс, хүнсний ногоо;

⁸ 19.1.4. тэжээлийн ургамал.

⁹ 16.1.12. хувь хүн өөрийн орлого болон банк, санхүүгийн байгууллагаас авсан зээлийн хөрөнгөөр амьдран суух зориулалтаар анх удаа хувьдаа орон сууцны барилга барих, эсхүл худалдан авахад зарцуулсан 30.0 сая төгрөгөөс дээшгүй хэмжээний хөрөнгөтэй тэнцэх орлого.

¹⁰ 24.6. Албан татвар төлөгчийн төрсөн буюу үрчилсэн хүүхэд гадаад, дотоодын их, дээд болон мэргэжлийн боловсролын сургууль, коллежид элсэн суралцаж байгаа бол түүний сургалтад төлсөн, баримтаар нотлогдож байгаа төлбөрийн хэмжээгээр албан татварын хөнгөлөлт үзүүлнэ.

¹¹ 24.7. Суралцаж байх хугацаандаа хөдөлмөр эрхлэлтийн орлогоосоо албан татвар төлж, улмаар сургалтын төлбөр төлсөн их, дээд болон мэргэжлийн боловсролын сургууль, коллежид суралцагчийг энэ хуулийн 24.6-д заасан хөнгөлөлтөд хамааруулна.

гүйцэтгэлийн аудитаар үзсэн тул энэ удаад тус аудитын шийдвэрийн хэрэгжилтийг авч үзэж ХХОАТ-ын хөнгөлөлт чөлөөлөлтийн талаарх мэдээ тайланг үндэслэн тайланд орууллаа.

Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн дагуу борлуулалтын орлогын дүнгээс татварын чөлөөлөлт эдэлсэн аж ахуйн нэгжүүдээс 10.0 сая төгрөгөөс дээш мөнгөн дүнтэй 9 байгууллагын 751.9 сая төгрөгийн борлуулалтын орлогод буюу нийт татварын чөлөөлөлт эдэлсэн аж ауйн нэгжийн 35.7 хувь нийт чөлөөлөлт эдэлсэн борлуулалтын орлогын 80 хувийг сонгон авч шалгалаа. Аудитаар сонгосон аж ахуйн нэгжүүдээс “Агь нарын овоо” ХХК-ны 2015-2016 онд татварын чөлөөлөлтөд хамрагдсан 29.1 сая төгрөгийн борлуулалт эзэн нас барсан, гэр бүлийн бусад гишүүд шилжсэн шалтгаанаар хамрагдаагүй болно.

Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн дагуу 6 аж ахуйн нэгжийн 0.38 сая төгрөгийн татварын хөнгөлөлт эдэлсэн байгаагаас 10.0 сая төгрөгөөс дээш борлуулалтын орлоготой буюу 3 аж ахуйн нэгжийн 0.25 сая төгрөгийн татварын хөнгөлөлт, 1 аж ахуйн нэгжийн 109.1 сая төгрөгийн борлуулалтын орлогын чөлөөлөлт байгааг буюу нийт аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн дагуу хөнгөлөлт чөлөөлөлт эдэлсэн аж ахуйн нэгжийн 50 хувь, татварын хөнгөлөлтийн 65 хувь, татварын чөлөөлөлт эдэлсэн 1 аж ахуйн нэгжийг буюу 100 хувийг тус тус аудитад хамрууллаа.

Уг аудиттай холбоотойгоор ҮАГ-аас ирсэн судалгаанд Говь-Алтай аймгийн хэмжээнд НӨАТ-ын чөлөөлөлт эдэлсэн 28 аж ахуйн нэгжийн 947.6 сая төгрөгийн мэдээлэл ирснийг аймгийн Татварын хэлтэс болон ҮАГ-ын ГАГ-ын аудитор Ц.Цолмонтой тулгалт хийж Монгол-Хятадын “Аксу Алтай” ХХК нь 88.7 сая төгрөгийн татварын чөлөөлөлт эдлээгүй болохыг гаргаж НӨАТ-ын чөлөөлөлт эдэлсэн аж ахуйн нэгжүүдийн нэгдсэн мэдээллээс хассан болно.

БҮЛЭГ:1 Иргэд, аж ахуйн нэгжүүд татварын хөнгөлөлт, чөлөөлөлт эдлэх боломжоо хангалттай түвшинд ашиглахгүй байна.

1.1 Татварын хөнгөлөлт чөлөөлөлтийн талаар баримталж буй бодлого байна уу?

Аймгийн Татварын хэлтэс нь Татварын ерөнхий хуулийн 22 дугаар зүйлийн 22.1.1¹², 22.1.2¹³ дахь заалтаар Сангийн яам, Татварын ерөнхий газраас баталж өгсөн аргачлалаар хуулийг сурталчлан таниулах, хуулийн хэрэгжилтэнд хяналт тавих чиг үүргийн хүрээнд үйл ажиллагаа явуулдаг ба хийх ажлын чиг үүргийн дагуу татварын хөнгөлөлт чөлөөлөлт нь тус байгууллагын үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдан хэрэгжиж байна.

Татварын хөнгөлөлт чөлөөлөлтийн асуудал нь тухайлсан хуулиудын цаглабар хугацаанд иргэн, аж ахуйн нэгжийн тайлагнасан тайлан, тооцоогоор баталгаажин эдлэгдэж байна.

¹² 22¹.1.1.Татварын хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, татвар төлөгчийг мэдээллээр ханган зөвлөгөө өгөх, сургалт, сурталчилгаа явуулах;

¹³ 22¹.1.2.Татварын хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих;

1.2 Татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийн бодлогыг хэрэгжүүлэх арга хэмжээ холбогдох байгууллагуудын үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан уу?

Аймгийн Татварын хэлтэс нь хууль таниулан сурталчлах ажлын хүрээнд 2015-2016 оны сургалтын төлөвлөгөөний дагуу Хувь хүний орлогын албан татварын тухай, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулиудаар нийт татвар төлөгч иргэн, аж ахуйн нэгжүүдэд сургалт зохион байгуулан ажилласан байгаа нь сайшаалтай байна. Дээрх сургалтуудыг ТЕГ-ын сургалтын баг тусгай удирдамжийн дагуу зохион байгуулсан ба сургалтанд нийтдээ 7,391 татвар төлөгч оролцож 11,960 ширхэг сурталчилгааны материал тараагдсан байна. Мөн аймгийн Татварын хэлтэс нь татвар төлөгчидтэй харилцах тасгаар дамжуулан иргэн аж ахуйн нэгжүүдэд нээлттэйгээр татварын аливаа асуудлаар заавар зөвлөгөө өгөх, шинэчлэгдсэн хуулийн заалтыг хэрэгжүүлэх таниулан сурталчлах, тайлангийн хугацааг сануулах, тайлан мэдээг хүлээн авах зэрэг ажлыг өдөр тутам явуулж байна. Аймгийн Татварын хэлтсийн зүгээс иргэд, ААН-үүдэд хууль таниулан сурталчлах ажлыг тодорхой төлөвлөгөөний дагуу зохион байгуулж байгаа боловч татварын хөнгөлөлт чөлөөлөлт эдэлж байгаа иргэн, ААН-ийн тоо цөөн байгаа нь сургалтын үр дүн хангалтгүй байгааг харуулж байна.

1.3 Татварын хөнгөлөлт чөлөөлөлтийн бодлого нийгэм эдийн засагт үр дүнгээ өгч байна уу?

Аймгийн Татварын хэлтэст 2015-2016 онд 656-662 ААН бүртгэлтэй байгаагаас 202-270 НӨАТ төлөгч ААН байна. Татварын хэлтэст бүртгэлтэй ААН-ийн тоо өсөх НӨАТ төлөгч ААН-ийн тоо буурах хандлагатай тоон үзүүлэлт гарч байна. Нийт НӨАТ төлөгч аж ахуйн нэгжийн 12 хувь нь НӨАТ-ын чөлөөлөлт эдэлсэн байна. Татварын хөнгөлөлт чөлөөлөлт эдэлж байгаа ААН-ийн тоо бага байгаа нь иргэдийн хуулийн мэдлэг хангалтгүй, хөнгөлөлт, чөлөөлөлт эдлэх хуулийн боломжоо ашиглахгүй байгаагаас шалтгаалж байна.



Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 13 дугаар зүйлийн дагуу 2015 онд 588.9 сая төгрөг, 2016 онд 358.7 сая төгрөгийн борлуулалтын орлого татвараас чөлөөлөгдсөн ба энэ нь 2015 онд орсон татварын орлогын 8.2 хувь, 2016 онд орсон татварын орлогын 4.6 хувийг тус тус эзлэж байна.

Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн дагуу 2015 онд 109.1 сая төгрөгийн борлуулалтын орлого татвараас

чөлөөлөгдсөн ба энэ нь 2015 онд орсон татварын орлогын 1.5 хувийг эзлэж байна. Мөн хуулийн дагуу 2015 онд 0.19 сая төгрөг, 2016 онд 0.19 сая төгрөгийн татвар ААНОАТ-аас хөнгөлөгдсөн байна.

Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн дагуу 2015 онд 517.1 сая төгрөг, 2016 онд 520.7 сая төгрөгийн хөнгөлөлт чөлөөлөлт эдлэгдсэн ба энэ нь 2015 онд орсон татварын орлогын 7.2 хувь, 2016 онд орсон татварын орлогын 6.7 хувийг эзлэж байна.

- ✓ Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн дагуу 27 аж ахуйн нэгжийн 858.9 сая төгрөгийн борлуулалт татвараас чөлөөлөгдсөн,
- ✓ Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн дагуу 6 аж ахуйн нэгж 0.38 сая төгрөгийн татварын хөнгөлөлт эдэлсэн, 1 аж ахуйн нэгжийн 109.1 сая төгрөгийн борлуулалт татвараас чөлөөлөгдсөн,
- ✓ Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн дагуу 2015-2016 онд 2585 иргэнд 1,037.8 сая төгрөгийн татварын буцаан олголт хийгдсэн, мөн 2015 онд 8524 иргэнд 555.3 сая төгрөгийн, 2016 онд 8467 иргэнд 510.3 сая төгрөгийн татварын хөнгөлөлт эдлүүлсэн байна.

Дээрхээс дүгнэхэд тухайлсан хуулиудад тусгагдсан татварын хөнгөлөлт чөлөөлөлт нь жижиг дунд үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд тодорхой хэмжээний үр ашгаа өгч иргэд, аж ахуйн нэгжийн төлөх татварын хэмжээ 2,103.8 сая төгрөгөөр буурч 968.0 сая төгрөгийн борлуулалт татвараас чөлөөлөгдсөн байна.

БҮЛЭГ 2. Татварын хөнгөлөлт, чөлөөлөлтөд хамрагдсан аж ахуйн нэгжүүдийн тухайд зохих хяналтыг хэрэгжүүлэн ажиллажээ.

2.1 Татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийг хэрэгжүүлэгч байгууллагууд мэдээ тайлангаа үнэн зөв, цаг хугацаанд нь гаргаж байна уу?

2015-2016 онд татвар төлөгчдийн ирүүлсэн тайланд НӨАТ-ын тухай хуулийн 13 дугаар зүйлд заасан бараа, үйлчилгээг татвараас чөлөөлсөн боловч “Ус-Алтай” ХХК 71.0 сая төгрөгийн /304-р кодоор чөлөөлөлт эдлэх орлогын дүнг 418-р кодоор тайлагнасан/, “Дашмянган” ХХК 11.9 сая төгрөгийн /304-р кодоор чөлөөлөлт эдлэх орлогын дүнг 432-р кодоор тайлагнасан/ хуулийн заалтын кодыг тайланд буруу тайлагнасан байна. Татварын чөлөөлөлт эдэлсэн байгууллагууд нь НӨАТ-ын тайлангаа Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1¹⁴ дахь заалтын дагуу хуулийн хугацаанд багтаан татварын цахим тайланд мэдээлсэн ба аймгийн татварын хэлтсийн зүгээс тайлангийн хугацаанд болон падаанаар хяналт тавьдаг боловч дээрх 2 аж ахуйн нэгжийн тухайд татварын чөлөөлөлт эдлэх заалтыг бүрэн гүйцэт шалгаж аваагүй байна.

Аймгийн Татварын хэлтэст 2015 онд дунджаар аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тайлан өгвөл зохих 636 аж ахуйн нэгж байгаагаас 600 аж ахуйн нэгж тайлангаа хугацаанд нь өгч 36 аж ахуйн нэгж хугацаа хоцрон тайлан өгсөн ба нийт татвар төлөгч аж ахуйн нэгжүүдийн 181 нь “Х” тайлан өгсөн, 2016 онд дунджаар 666 аж ахуйн нэгж тайлан тушаавал зохихоос 631 аж ахуйн нэгж хугацаандаа тайлангаа өгсний 225 нь “Х” тайлан өгч 35 аж ахуйн нэгж хугацаа хоцорч тайлан өгсөн байна.

2015 онд дунджаар НӨАТ-ын тайлан тушаавал зохих 251 байгууллагын 84 нь “Х” тайлан гаргаж 250 аж ахуйн нэгж хугацаандаа тайлангаа өгч 1 аж ахуйн нэгж хугацаа хоцорч тайлан тушаасан, 2016 онд дунджаар НӨАТ-ын тайлан тушаавал зохих 237 аж ахуйн нэгж байгууллага байгаагийн 67 нь “Х” тайлан өгч 238 аж ахуйн нэгж хугацаандаа тайлан мэдээгээ өгсөн ба 1 аж ахуйн нэгж нэмж бүртгэгдсэн тоо мэдээ байна. Тайлан хоцроосон аж ахуйн нэгжүүдийн тухайд татварын ерөнхий хуулийн 4.1.8 а-ж дэх заалтуудын дагуу


¹⁴ 16.1. Албан татвар төлөгч нь бараа, ажил, үйлчилгээнд ногдох нэмэгдсэн өртгийн албан татварыг дор дурдсан журмаар дараа сарын 10-ны дотор төрийн сангийн нэгдсэн дансанд шилжүүлж, батлагдсан маягтын дагуу тайлангаа харъяалах татварын албанд тушаана:

хүндэтгэн үзэх шалтгаантай байсан тайлбар албан тоотыг үндэслэн хугацаа хоцорсон тайланг хүлээн авсан байна.

Аймгийн Татварын хэлтсийн мэдээ, тайлан цахим хэлбэрээр төвдөө нэгтгэгдэн мэдээллийн бааз болон хадгалагддаг байна. Татварын хөнгөлөлт чөлөөлөлтийн хэрэгжилт, үр дүнгийн талаар олон нийтэд нийт багцалсан дүнгээр цахим хаягууд /вэб хуудас болон Facebook/ “Миний нутаг” телевиз, “Алтайн мэдээ” сонингоор дамжуулан мэдээлэл хийгдсэн байна.

2.2 Татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийг зохих хууль журмын дагуу эдлүүлсэн үү?

Аудитад хамрагдсан 10 аж ахуйн нэгжээс “Агь нарын овоо” ХХК-ны 29.2 сая төгрөгийн татвараас чөлөөлөгдсөн борлуулалт эзэн нас барсан, гэр бүлийн бусад гишүүд шилжсэн шалтгаантайгаар аудитад хамрагдаагүй болно. Баримт материал ирүүлсэн аж ахуйн нэгжүүдээс Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 13 дугаар зүйлийн дагуу борлуулалтын орлогын дүнгээс татварын чөлөөлөлт эдэлж байгаа аж ахуйн нэгжүүдийн 34 хувь нь Хүчингүй болсон хуулийн 13.1.4 дэх заалт, мөрдөгдөж байгаа хуулийн 13.1.3¹⁵ дахь заалтаар чөлөөлөгдөх борлуулалтын орлого олжээ.



Дээрхээс гадна НӨАТ-ын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.15¹⁶ дахь заалтын дагуу “Баянтооройн бүрд” ХХК борлуулсан будаа хүнсний ногооны орлогоос олсон 101.6 сая төгрөг, “Мөрөн-Алтай” ХХК 13.5.10¹⁷ дахь заалтын дагуу эрүүл мэндийн үйлчилгээ

Хүснэгт-1

/сая. төгрөг/

№	ААН нэр	Санхүүжүүлсэн байгууллага	Хийсэн ажил	Мөнгөн дүн
1	Дашмянган ХХК-2016	Дэлхийн зөн ОУБ	Бараа нийлүүлсэн	11.9
2	Ус Алтай ХХК-2015	33 ба бэлчээрийн удирдлагын төсөл	Худаг засвар	71.1
		Өвсний үндэс хөтөлбөр	1 дүгээр цэцэрлэг засвар	165.8
3	Хонгор буурал ХХК-2015	Өвсний үндэс хөтөлбөр	Бигэр сумын дунд сургууль засвар	36.4
4	Модон чөлөө ХХК-2016	Дэлхийн зөн ОУБ	Эрдэнэ сумын дунд сургуулийн засвар	55.0
5	Алтайн нуруун шонхор ХХК-2015	Дэлхийн зөн ОУБ	Бараа нийлүүлсэн	1.4
6	Вантайшир ХХК-2015	Каратис монгол төсөл	Хоршоологчдын холбооны байр засвар	32.5
7	Хүслэнт хүдэр ХХК-2016	Бэлчээрийн менежментийн холбоо	Хөхморьт сумд Ногоон алт хөтөлбөрийн байр барих ажил	40.0
Дүн				414.1

¹⁵13.1.4 болон 13.1.3 Гадаад улсын Засгийн газар, төрийн бус байгууллага, олон улсын байгууллагаас буцалтгүй болон хүмүүнлэгийн тусламж, хөнгөлөлттэй зээлээр авсан бараа;

¹⁶ 13.1.18 болон 13.1.15 Газар тариалан эрхлэгчийн дотооддоо тарьж борлуулсан үр тариа, төмс, хүнсний ногоо, жимс жимсгэнэ, үйлдвэрлэсэн гурил

¹⁷ 13.6.10 болон 13.5.10 эрүүл мэндийн үйлчилгээ;

үзүүлж 172.4 сая төгрөгийн орлого олсон дүнгээр татварын чөлөөлөлт эдэлсэн байна. Засгийн газрын 2012 оны 2 дугаар сарын 15-ны өдрийн 48 дугаар тогтоолын дагуу ¹⁸ “Алтайннуруун шонхор” ХХК нь 63.6 сая төгрөгийн өртөгтэй трактор болон дагалдах хэрэгслийг нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлсөн байна. /Хуучин хуулиар 2016 онд хүчингүй болсон ба уг байгууллага 2015 онд чөлөөлөлт эдэлсэн/

Татварын чөлөөлөлт эдэлсэн аж ахуйн нэгжүүд нь нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 13 дугаар заалтыг хангасан дээрх бараа, ажил үйлчилгээг гүйцэтгэхдээ үндсэн 3 орон тоо, гэрээтээр 44 ажлын байр бий болгож ажилласан ба байнгын орон тоо 54 хүрсэн байна.

ААНОАТ тухай хуулийн 19 дүгээр зүйлд заасан заалтуудыг хангасан аж ахуйн нэгжид хөнгөлөлт эдлүүлэхээр хуулинд заасан байдаг ба аймгийн хэмжээнд 2015-2016 онд үр тариа, төмс хүний ногоо, тэжээлийн ургамал тарьсан хоршоонууд татварын хөнгөлөлт эдэлсэн байна. /Хүснэгт-2/

Хүснэгт-2

/сая.төгрөг/

№	Байгууллагын нэр	2015 он			2016 он		
		БО	ББӨ	Хөнгөлөгдөх татварын дүн	БО	ББӨ	Хөнгөлөгдөх татварын дүн
1	Говийн ургац хоршоо	5.5	4.3	0.06	14.3	13.7	0.028
2	Мянганы говь хоршоо	9.6	9.0	0.03	5.1	4.6	0.023
3	Түмэн арвай ЗБН	4.1	3.1	0.05	3.0	2.8	0.045
4	Тавиун тал хоршоо	8.2	7.2	0.05	21.5	20.4	0.06
5	Добувежи ББН				1.1	0.35	0.0175
6	Агро Гуулин хоршоо				9.4	8.9	0.021
	Дүн	27.4	23.6	0.19	54.4	50.75	0.19

Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн дагуу татварын хөнгөлөлт эдлүүлэхдээ Татварын хэлтсийн даргын 2016 оны 07 дугаар сарын 04-ны өдрийн А/23 тоот тушаал, 2017 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн А/23 тоот тушаалаар хөнгөлөлт эдлэх байгууллагуудын жагсаалтыг баталжээ. Үүнээс аудитын хугацаанд Говийн ургац хоршоо, Мянганы говь хоршоо, Тавиун тал хоршоонуудын татварын хөнгөлөлт болох 0.25 сая төгрөгийн хөнгөлөлтийг түүвэрлэн авч үзэхэд нийт 64.5 сая төгрөгийн борлуулалтын орлого олсны 31.1 сая төгрөг нь борлуулсан бүтээгдэхүүний өртөг, 27.6 сая төгрөг нь удирдлагын болон борлуулалтын үйл ажиллагааны зардал байж татвар ногдох орлогын дүн 5.8 сая төгрөгтэй тэнцэн 0.5 сая төгрөгийн татвар ногдож 0.25 сая төгрөгийн татварын хөнгөлөлт эдэлсэн байгаа нь үнэн зөв байна.

ХХОАТ-ын буцаан олголтыг 2015 онд хийсэн “Татвар болон татварын бус орлогын төлөвлөлт бүрдүүлэлт, үр дүн” гүйцэтгэлийн аудитад өмнөх 9 оны баримт материалыг хамруулан үзэж шийдвэр гаргасанд тулгуурлан энэ удаад зөвхөн өмнөх шийдвэрийн хэрэгжилтийг үзэж олголтын талаар аймгийн Татварын хэлтсээс гаргасан мэдээ тайлан тушаалыг үндэслэн тайланд тусгасан болно.

¹⁸ Гаалийн албан татвар, нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөгдөх импортоор оруулж байгаа дотооддоо худалдан борлуулах хөдөө аж ахуй зориулалттай шинэ трактор, комбайн, машин механизм гурилын үйлдвэрийн болон усалгааны тоног төхөөрөмж, ойн аж ахуйн техник, бордоо ургамал хамгааллын бодисыг татвараас чөлөөлөх жагсаалт

ХХАОТ-ын тухай хуулийн дагуу татварын буцаан олголт хийхээс гадна мөн ажил эрхэлж байгаа хувь хүнд жилд 0.084 сая төгрөгийн татварын хөнгөлөлт үзүүлж байгаа ба 2015 онд 8524 иргэнд 555.3 сая төгрөгийн, 2016 онд 8467 иргэнд 510.3 сая төгрөгийн хөнгөлөлт үзүүлжээ. Энэ хөнгөлөлт нь тухайн хувь хүний ажиллаж буй байгууллагын ТТ-11 тайлангаар илэрхийлэгдэж байна.

Өмнөх аудитын хэрэгжилтийн талаар:

Хувь хүний орлогын албан татварын буцаан олголтыг 2015 онд хийсэн “Татвар болон татварын бус орлогын төлөвлөлт бүрдүүлэлт, үр дүн” гүйцэтгэлийн аудитаар хууль хэрэгжиж эхэлсэн оноос хойш буюу 2007-2015 оны мөчлөгт орон сууцны хөнгөлөлт эдэлсэн иргэдийн материалыг сонгон авч давтан тооцоолол хийж зөрүүг тооцоолсон ба ингэхдээ үл хөдлөх хөрөнгө худалдан борлуулсан 2 хувийн татварын тооцооллыг хөнгөлөлт эдэлсэн иргэдийн хэмжээнд мөн давхар үзсэн. Аудитад нийтдээ 9 оны баримт материал буюу давхардсан тоогоор 5,877 иргэний хувийн хэргээс 5,064 хувийн хэргийг хамруулан нэг бүрчлэн үзсэн шалгалтын явцад үл хөдлөх эд хөрөнгө худалдан борлуулсны 2 хувь төлөөгүй иргэдэд хөнгөлөлт олгосон, программын алдаанаас илүү олголт үүссэн зөрчил илэрч байсан ба тус аудитаар ХХАОТ-ын хөнгөлөлт чөлөөлөлттэй холбоотой доорх зөрчил илэрч байжээ. Үүнд:

- ✓ ХХАОТ-ын буцаан олголтыг хөөн шалгахад 7 иргэнд 2.7 сая төгрөг илүү олгосон
- ✓ ХХАОТ-ын буцаан олголтыг хөөн шалгахад нэр бүхий 3 иргэн 5.0 сая төгрөгийн хөнгөлөлт эдэлсэн боловч холбогдох баримт материалын бүрэн бүрдүүлэлгүйгээр хөнгөлөлт олгосон
- ✓ ХХАОТ-ын буцаан олголтыг хөөн шалгахад 2007-2010 оны олголтод холбогдох баримт материалыг бүрэн бүрдүүлэлгүйгээр олголт хийсэн, хөнгөлөлт эдлэх явцад хөрөнгийн үнэлгээг баримтгүйгээр нэмэгдүүлсэн, үл хөдлөх эд хөрөнгө худалдан борлуулсны 2 хувийн татвар төлөөгүй иргэдэд хөнгөлөлт эдлүүлсэн зэрэг 18.4 сая төгрөгийн алдаа илэрч нийт 2.7 сая төгрөгийн зөрчилд орон нутгийн орлогод төвлөрүүлэх төлбөрийн акт, 5.0 сая төгрөгийн зөрчилд баримт материал бүрдүүлэн нөхөж үзүүлэх хугацаатай албан шаардлага, 18.4 сая төгрөгийн алдаа зөрчилд ХХАОТ-ын буцаан олголтыг холбогдох шаардлагатай баримтыг бүрэн бүрдүүлж ирсэн иргэдэд олгож хэвших, холбогдох албан тушаалтанд хариуцлага тооцох албан шаардлагыг тус тус хүргүүлсэн ба шийдвэрийн хэрэгжилтийг давтан үзэхэд 2017 оны статистик мэдээгээр тус аудиттай холбоотой 2.05 сая төгрөгийн төлбөрийн актыг үлдэгдэл байсныг аудитын хугацаанд барагдуулан ажиллав.

2.3 Татварын хөнгөлөлт чөлөөлөлтөнд тавих хяналт үр дүнтэй байна уу?

Аймгийн Татварын хэлтэс нь аж ахуйн нэгжээс тайлан хүлээн авахдаа тайлангийн хэмжээнд хянаж хүлээн авч ажилласан талаар татвар төлөгчидтэй харилцах тасгийн улсын байцаагчдын зүгээс тайлбарлаж байгаа боловч хяналт хийсэн тэмдэглэл байхгүй байна. Түүвэрт хамрагдсан аж ахуйн нэгжүүдийн баримтыг шалгаж үзэхэд материаллаг зөрчил бага илэрсэн нь энэ талаар хэрэгжүүлж буй хяналт сайн байгааг харуулж байна.

ХХАОТ-ын тухай хуулийн дагуу татварын буцаан олголт өгөхдөө 2016 оноос хойш хүлээн авах, ирүүлсэн баримт материалын бүрдлийг шалгах, нийт жагсаалтаар олгогдох буцаан олголтын баримтыг баталгаажуулах гэсэн 3 дамжлагаар олголт хийдэг болсон нь өмнөх аудитын мөрөөр тодорхой ажил зохион байгуулж үр дүнг тооцож байгааг илтгэж байна.

Аймгийн татварын хэлтсийн эрсдлийн программ нь тухайн жил хяналт шалгалт хийх байгууллагуудыг 200-300 үзүүлэлтийн дагуу сонгон эрдлийг үнэлж тооцоолол хийдэг ба тухайн жил шалгалт хийх аж ахуйн нэгжүүдийг уг программаар сонгон ТЕГ-ын даргын тушаалаар баталгаажуулан шалгалт хийх байгууллагууд сонгогддог ба батлагдсан тушаалд орсон байгууллагуудад төлөвлөгөөт шалгалтыг хийж гүйцэтгэдэг байна.

Шалгалт хамрах 2015-2016 онд НӨАТ-ын тухай хуулиар чөлөөлөлт эдэлсэн, ААНОАТ тухай хуулиар хөнгөлөлт, чөлөөлөлт эдэлсэн, ХХОАТ хуулиар орон сууцны чөлөөлөлт, сургалтын төлбөрийн хөнгөлөлт эдэлсэн иргэн, аж ахуйн нэгжүүдэд төлөвлөгөөт шалгалт хийгдээгүй байна.

Ерөнхий дүгнэлт: Шинэчлэгдсэн хуулиудыг таниулан сурталчлах ажил хангалтгүйгээс татварын хөнгөлөлт, чөлөөлөлт эдэлж буй аж ахуйн нэгжийн тоо цөөн байна.

ДАРГА , ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Х.ТҮВШИНБАЯР